

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2017 ОНЫ 7 ДУГААР ХУРАЛДААН**

Хуралдаан 2017 оны дөрөвдүгээр сарын 17-ны 14 цаг 15 минутад эхэлж, 16 цаг 18 минут хүртэл Засаг даргын Тамгын газрын даргын өрөөнд болж, нийт 2 цаг 03 минут үргэлжлэв.

№	Хэлэлцэх асуудлын төлөвлөгөө	Шийдвэр
1	Төрийн албаны 2017 оны 03 сарын 16-ны өдрийн мэргэшлийн шалгалтаар нэр дэвшүүлсэн иргэдийн тухай	Төрийн албаны мэргэжлийн шалгалтанд тэнцэж, Төрийн албаны зөвлөлийн 2017-оны 04 сарын 07-ны өдрийн 80 дугаар тогтоолын 3. 4 дүгээр хавсралтаар нэр дэвшсэн дэс түшмэлийн 7, туслах түшмэлийн 6 нийт 13 иргэний тухайн албан тушаалд нь томилуулахаар холбогдох байгууллагад хүргүүлэхээр шийдвэрлэв.дугаар хавсралтаар нэр дэвшсэн
2	Хулд сумын Засаг даргын Тамгын газрын Төрийн сангийн мэргэжилтний албан тушаалд нөөцөөс нэр дэвшүүлэх тухай	Хулд сумын Засаг даргын Тамгын газрын Төрийн сангийн мэргэжилтний албан тушаалд Төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн Энхтайван овогтой Хонгорзулыг нэр дэвшүүлэв.
3	Дэлгэрцогт сумын Засаг даргын Тамгын газрын Төрийн сангийн мэргэжилтний албан тушаалд нөөцөөс нэр дэвшүүлэх тухай	Дэлгэрцогт сумын Засаг даргын Тамгын газрын Төрийн сангийн мэргэжилтний албан тушаалд Төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн Буяа овогтой Баатарсүрэнг нэр дэвшүүлэв
4	Гурвансайхан сумын ЗДТГ-ын мэргэжилтний албан тушаалд нөөцөөс нэр дэвшүүлэх тухай	Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын Малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтний албан тушаалд Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 80 дугаар тогтоолоор төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн Лхагвасүрэн овогтой Адъяацэрэнг нэр дэвшүүлэв.
5	Төрийн албаны салбар зөвлөлийн 2017 оны төлөвлөгөө батлах тухай	Төрийн албаны салбар зөвлөлийн 2017 оны төлөвлөгөөнд гишүүдийн саналыг тусгаж батлахаар шийдвэрлэв.
6	Төрийн албаны зөвлөлийн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах тухай	Төрийн албаны зөвлөлийн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд гишүүдийн саналыг тусгаж батлахаар шийдвэрлэв.
7	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдааны 2017 оны 1 дүгээр улирлын шийдвэрийн хэрэгжилт	2017 оны 1-р улиралд Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 6 хуралдаанаар 24 асуудал шийдвэрлэснээс хэрэгжилт 100%-21, 90%-3 98.75 байлаа. Хэрэгжилт дутуу байгаа 3 заалтын хангаж ажиллахыг ажлын албанд үүрэг болголоо.
8	Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын захиалгын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөөцөөс нөхөх тухай	Нутгийн захиргааны байгууллагуудын захиалгын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын дэс түшмэлийн 9, туслах түшмэлийн 3 нийт 12 сул орон тоог нөөцөөс нөхөх зард зарлуулахаар ТА3-д хүргүүлэхээр шийдвэрлэв.
9	Уламжлалт анагаах ухааны төвийн дарга, Зоонозын өвчин судлалын төвийн дарга, Гурвансайхан, Цагаандэлгэр, Говь-Угтаал сумын Эрүүл мэндийн төвийн дарга, Цагаандэлгэр сумын Соёлын төвийн эрхлэгчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалт зарлах тухай	Цагаандэлгэр сумын ЗДТГ-ын Санхүүгийн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч, Уламжлалт анагаах ухааны төвийн дарга, Зоонозын өвчин судлалын төвийн дарга, Гурвансайхан, Цагаандэлгэр, Говь-Угтаал сумын Эрүүл мэндийн төвийн дарга, Цагаандэлгэр сумын Соёлын төвийн эрхлэгчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалт зарлах тухай ТА3-д хүргүүлж, зарлахаар шийдвэрлэв.

